

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/152/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайшанид сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 4-6/206

тантай _____-ны № _____-г

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ
1-Р СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.СҮРЭНХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах,

0190 04 9

санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 22.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Илрүүлэлтээр шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 3,302.3 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,586.5 сая төгрөгийн 55 гүйлгээ, 47.9 сая төгрөгийн 5 зардал гаргах шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 422.6 сая төгрөгийн орлогын 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 55.6 сая төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 35.1 сая төгрөгийн 8 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", заалтуудтай нийцээгүй байна.

Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 4 харилцагчдаас 3.6 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 24 арга хэмжээний хэрэгжилт 80.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.7 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т. ГАН-ӨЛЗИЙ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	174,627,463.86	264,275,863.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	22,301,582.97
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	22,301,582.97
3121	Төгрөг	-	22,301,582.97
31211	Төрийн сангийн харилцах	-	22,301,582.97
33	АВЛАГА	7,803,012.37	783,312.41
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,735,117.22	523,917.47
335	Бусад авлага	67,895.15	259,394.94
3351	Байгууллагаас авах авлага	1,977.15	193,476.94
3352	Хувь хүмүүсээс авах авлага	65,918.00	65,918.00
34	УРЬДЧИЛГАА	-	54,108,500.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	54,108,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	166,824,451.49	187,082,468.49
351	Түүхий эд материал	85,895,622.89	85,895,622.89
35110	Тусгай зориулалттай материал	85,895,622.89	85,895,622.89
35300	Бэлэн бүтээгдэхүүн	33,499,569.00	38,836,156.00
354	Хангамжийн материал	47,429,259.60	62,350,689.60
35410	Бичиг хэргийн материал	-	108,000.00
35420	Аж ахуйн материал	42,268,233.60	55,189,393.60
35440	Түлш, шатах тослох материал	310,000.00	-
35460	Хүнсний материал	974,390.00	3,176,660.00
35470	Бусад хангамжийн материал	3,876,636.00	3,876,636.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,592,155,703.73	3,466,924,982.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,592,155,703.73	3,466,924,982.03
392	Биет хөрөнгө	3,375,815,786.93	3,251,106,815.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,117,745,676.89	5,114,384,076.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,066,944,130.77)	(2,177,247,613.58)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	300,695,050.19	331,091,692.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(146,846,766.65)	(172,646,316.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	233,955,260.13	190,845,571.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(109,589,473.32)	(91,550,628.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,132,986.59	16,549,509.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(23,440,689.13)	(8,088,354.42)
39217	Ном	37,107,873.00	47,768,879.00
393	Биет бус хөрөнгө	216,339,916.80	215,818,166.88
39301	Програм хангамж	4,904,798.00	2,177,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,454,881.20)	(1,248,833.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	214,890,000.00	214,890,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,766,783,167.59	3,731,200,845.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	422,721.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	422,721.50
413	Өглөг	-	422,721.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	422,721.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,766,783,167.59	3,730,778,124.40
51	Засгийн газрын хувь оролцоо	3,766,783,167.59	3,730,778,124.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,577,698,149.51	1,577,698,149.51
51101	Өмч: - төрийн	1,577,698,149.51	1,577,698,149.51
512	Хуримтлагдсан үр дүн	(551,621,678.74)	(587,626,721.93)
51210	Өмнөх үеийн үр дүн	(551,621,678.74)	(537,921,678.74)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(49,705,043.19)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,740,706,696.82	2,740,706,696.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,766,783,167.59	3,731,200,845.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,338,426,954.25	2,802,692,076.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,168,517,640.00	42,466,624.76
120	Нийтлэг татварын бус орлого	625,140.00	42,466,624.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,592,790.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,592,790.00
120009	Бусад орлого	625,140.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	27,890,770.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	5,983,064.76

123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,167,892,500.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,029,894,400.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	137,998,100.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,169,909,314.25	2,760,225,452.08
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,842,555,300.00	2,412,329,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,412,329,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,842,555,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,957,187.00	4,039,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,603,647.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,353,540.00	4,039,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	267,396,827.25	343,856,552.08
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	267,396,827.25	343,856,552.08
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,303,040,461.54	2,852,397,120.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,303,040,461.54	2,852,397,120.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,239,748,966.23	2,655,073,120.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,490,929,255.99	1,835,753,170.91
210101	Үндсэн цалин	842,055,505.65	1,204,130,609.27
210102	Нэмэгдэл	591,923,266.05	593,245,501.98
210104	Урамшуулал	56,950,484.29	37,888,056.42
210105	Гэрээт ажлын хөлс	-	489,003.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,744,838.48	228,694,381.32
210201	Тэтгэврийн даатгал	141,150,860.19	155,408,746.45
210202	Тэтгэмжийн даатгал	11,760,051.94	18,334,186.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,111,917.56	14,667,069.53
210204	Ажилгүйдлийн даатгал	1,926,979.98	3,662,370.78
210205	Эрүүл мэндийн даатгал	20,795,028.81	36,622,007.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	254,637,119.47	277,439,820.34
210301	Гэрэл, цахилгаан	16,625,297.48	15,030,101.90
210302	Түлш, халаалт	217,074,792.22	243,990,300.00
210303	Цэвэр, бохир ус	20,937,029.77	18,419,418.44
2104	Хангамж, бараа материалын зардал	22,340,171.97	310,000.00
210401	Бичиг хэрэг	1,904,837.00	-
210402	Тээвэр, шатахуун	3,010,000.00	310,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,169,880.00	-
210404	Ном, хэвлэл	9,510.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,995,944.97	-
2105	Нормативт зардал	18,071,210.00	29,381,520.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,937,000.00	-
210502	Хоол, хүнс	14,023,010.00	29,381,520.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,111,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,453,600.00	5,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	934,000.00	-
210604	Урсгал засвар	33,519,600.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	971,323.00	-
210702	Дотоод албан томилолт	971,323.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,046,470.00	2,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,139,270.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	907,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	216,554,977.32	275,794,227.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	70,778,509.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,230,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	212,824,977.32	205,015,717.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,291,495.31	197,324,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,921,700.00	197,324,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,489,700.00	164,137,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,432,000.00	33,186,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,369,795.31	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,369,795.31	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,035,386,492.71	(49,705,043.19)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	38,267,817.15	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	38,267,817.15	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(38,267,817.15)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	997,118,675.56	(49,705,043.19)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,338,426,954.25	2,793,866,842.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,168,517,640.00	33,641,390.00
120	Нийтлэг татварын бус орлого	625,140.00	33,641,390.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	33,641,390.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	19,941,390.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	13,700,000.00
120009	Бусад орлого	625,140.00	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,167,892,500.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,029,894,400.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	137,998,100.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,169,909,314.25	2,760,225,452.08
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,842,555,300.00	2,412,329,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,412,329,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,842,555,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,957,187.00	4,039,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,603,647.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,353,540.00	4,039,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	267,396,827.25	343,856,552.08
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	267,396,827.25	343,856,552.08
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,097,330,654.25	2,719,671,033.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,097,330,654.25	2,719,671,033.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,034,039,158.94	2,522,347,033.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,498,664,373.21	1,828,310,749.45
210101	Үндсэн цалин	849,790,622.87	1,194,409,497.81
210102	Нэмэгдэл	592,811,936.99	593,245,501.98
210104	Урамшуулал	56,061,813.35	40,166,746.42
210105	Гэрээт ажлын хөлс	-	489,003.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,744,838.48	228,694,381.32
210201	Тэтгэврийн даатгал	141,150,860.19	155,408,746.45
210202	Тэтгэмжийн даатгал	11,760,051.94	18,334,186.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,111,917.56	14,667,069.53
210204	Ажилгүйдлийн даатгал	1,926,979.98	3,662,370.78
210205	Эрүүл мэндийн даатгал	20,795,028.81	36,622,007.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	258,816,827.25	277,439,820.34
210301	Гэрэл, цахилгаан	16,625,297.48	15,030,101.90
210302	Түлш, халаалт	221,254,500.00	243,990,300.00
210303	Цэвэр, бохир ус	20,937,029.77	18,419,418.44
2104	Хангамж, бараа материалын зардал	14,864,527.00	-
210401	Бичиг хэрэг	1,895,347.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,169,880.00	-
210404	Ном, хэвлэл	499,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,249,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,850,600.00	-
2105	Нормативт зардал	19,045,600.00	31,583,790.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,937,000.00	-
210502	Хоол, хүнс	14,997,400.00	31,583,790.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,111,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,457,400.00	5,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,997,400.00	-
210604	Урсгал засвар	28,460,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	971,323.00	-
210702	Дотоод албан томилолт	971,323.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,047,270.00	10,687,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,068,070.00	7,987,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	979,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,427,000.00	140,631,192.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,160,000.00	114,338,612.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,267,000.00	26,292,580.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,291,495.31	197,324,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,921,700.00	197,324,000.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,489,700.00	164,137,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,432,000.00	33,186,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,369,795.31	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,369,795.31	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,241,096,300.00	74,195,808.97
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	72,541,390.00	51,894,226.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	72,541,390.00	51,894,226.00
2200	Дотоод эх үүсвэрээр	72,541,390.00	51,894,226.00
222001	Тоног төхөөрөмж	72,091,390.00	46,733,000.00
223001	Бусад хөрөнгө	450,000.00	5,161,226.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(72,541,390.00)	(51,894,226.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,168,554,910.00	22,301,582.97
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		22,301,582.97

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,577,698,149.51	2,740,706,696.82	(537,921,678.74)	3,780,483,167.59
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,577,698,149.51	2,740,706,696.82	(537,921,678.74)	3,780,483,167.59
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	49,439,503.54	49,439,503.54
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,577,698,149.51	2,740,706,696.82	(551,621,678.74)	3,766,783,167.59
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,577,698,149.51	2,740,706,696.82	(551,621,678.74)	3,766,783,167.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	13,700,000.00	13,700,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,577,698,149.51	2,740,706,696.82	(537,921,678.74)	3,780,483,167.59
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(49,705,043.19)	(49,705,043.19)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,577,698,149.51	2,740,706,696.82	(587,626,721.93)	3,730,778,124.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,789,166,800.00	2,771,565,259.11	17,601,540.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,789,166,800.00	2,771,565,259.11	17,601,540.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,597,200,700.00	2,574,241,259.11	22,959,440.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,832,920,000.00	1,828,310,749.45	4,609,250.55
210101	Үндсэн цалин	1,408,919,500.00	1,194,409,497.81	214,510,002.19
210102	Нэмэгдэл	384,699,800.00	593,245,501.98	(208,545,701.98)
210104	Урамшуулал	39,300,700.00	40,166,746.42	(866,046.42)
210105	Гэрээт ажлын хөлс	-	489,003.24	(489,003.24)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	231,670,600.00	228,694,381.32	2,976,218.68
210201	Тэтгэврийн даатгал	157,536,100.00	155,408,746.45	2,127,353.55
210202	Тэтгэмжийн даатгал	18,533,600.00	18,447,886.91	85,713.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,826,900.00	14,553,369.53	273,530.47
210204	Ажилгүйдлийн даатгал	3,706,800.00	3,662,370.78	44,429.22
210205	Эрүүл мэндийн даатгал	37,067,200.00	36,622,007.65	445,192.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,624,400.00	277,439,820.34	9,184,579.66
210301	Гэрэл, цахилгаан	20,000,000.00	15,030,101.90	4,969,898.10
210302	Түлш, халаалт	243,990,300.00	243,990,300.00	-
210303	Цэвэр, бохир ус	22,634,100.00	18,419,418.44	4,214,681.56
2105	Нормативт зардал	31,584,200.00	31,583,790.00	410.00
210502	Хоол, хүнс	31,584,200.00	31,583,790.00	410.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-

210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,515,500.00	20,187,100.00	5,328,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,987,100.00	7,987,100.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,528,400.00	12,200,000.00	5,328,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	183,886,000.00	183,025,418.00	860,582.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	157,593,400.00	156,732,838.00	860,562.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,292,600.00	26,292,580.00	20.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	191,966,100.00	197,324,000.00	(5,357,900.00)
2132	Бусад урсгал шилжүүлэг	191,966,100.00	197,324,000.00	(5,357,900.00)
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	169,179,200.00	164,137,500.00	5,041,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,786,900.00	33,186,500.00	(10,399,600.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,789,166,800.00	2,793,866,842.08	(4,700,042.08)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,412,329,900.00	2,428,323,190.00	(15,993,290.00)
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,412,329,900.00	2,412,329,900.00	-
131104	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		9,085,490.00	(9,085,490.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон		6,907,800.00	(6,907,800.00)
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	353,041,300.00	343,856,552.08	9,184,747.92
132001	Орон нутгийн төсвөөс	353,041,300.00	343,856,552.08	9,184,747.92
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	23,795,600.00	21,687,100.00	2,108,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,987,100.00		7,987,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,808,500.00	7,987,100.00	7,821,400.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	13,700,000.00	(13,700,000.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		22,301,582.97	(22,301,582.97)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	115.00	106.00	9.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	86.00	81.00	5.00
620003	Үйлчлэх ажилтан	28.00	24.00	4.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,611.00	1,624.00	(13.00)
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,611.00	1,624.00	(13.00)
630001	Төрийн өмчит ЕБС	1,611.00	1,624.00	(13.00)
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	115.00	106.00	9.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	87.00	82.00	5.00
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	1.00	1.00	-
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26.00	22.00	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,039,000.00
213305	Нэмэлтийн үлдэгдэл төвлөрүүлэх шилжүүлэг		4,039,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	4,039,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,039,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,039,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 129.2 сая төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс аудитын явцад 129.2 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Түрээсийн сурах бичгийн орлого 8.0 сая төгрөг, цайны газрын түрээсийн орлогын 50% болох 3.4 сая төгрөгийг орлого үр дүнгийн тайланд нэмэлт орлогоор бүртгэснийг залруулсан;
2. Санхүү байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 13.7 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулсан;
3. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 98.8 сая төгрөгөөр дутуу байгуулсныг залруулсан.
4. 5.3 сая төгрөгийн эргэлтийн түрээсийн сурах бичгийг үндсэн хөрөнгөнд бүртгэснийг бараа материалд шилжүүлж залруулсан.

Аудитаар нийт 4 зөрчил² илэрснээс 1 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 3,302.3 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,586.5 сая төгрөгийн 55 гүйлгээ, 47.9 сая төгрөгийн 5 зардал гаргах шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 422.6 сая төгрөгийн орлогын 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 55.6 сая төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 35.1 сая төгрөгийн 8 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй байна.

2. Авлагатай холбоотой асуудал

БШУСайдын 2022 оны А/452 тоот тушаалын дагуу хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтаар 54.1 сая төгрөг шилжүүлсэн ч хөрөнгөө хүлээж аваагүй байна. Энэ нь хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, бодитой мэдээллээр хангагдахгүй байх, тогтоол шийдвэр хэрэгжихгүй байх үр дагавартай.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн “41.2.3 төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах; 41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалтуудтай нийцээгүй ба тохиолдсон байх, иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй. Энэ нь өмч, хөрөнгө дутагдах, ашиггүй зарцуулагдах, бодитой мэдээллээр хангагдаж чадахгүй байх үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч сар бүр эд хариуцагчийн тайланг хянан, хэмжээ, тоо ширхэгийг тодорхой гаргаж, гарын үсэг болон бусад баталгаажуулалтыг ханган хариуцлагатай ажиллах.

2. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 4 харилцагчдаас 3.6 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”; 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүчин төгөлдөр анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Түрээсийн сурах бичгийн орлого 8.0 сая төгрөг, цайны газрын түрээсийн орлогын 50% болох 3.4 сая төгрөгийг орлого үр дүнгийн тайланд нэмэлт орлогоор бүртгэсэн	1	11,348.6			1	11,348.6	1	11,348.6				
Санхүү байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 13.7 сая төгрөгөөр зөрүүтэй	1	13,700.0			1	13,700.0	1	13,700.0				
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 98.8 сая төгрөгөөр дутуу байгуулсан	1	98,763.9			1	98,763.9	1	98,763.9				
5.3 сая төгрөгийн эргэлтийн түрээсийн сурах бичгийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн	1	5,336.6			1	5,336.6	1	5,336.6				
Дүн	4	129,149.1			4	129,149.1	4	129,149.1	-	-		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй.	1						1					
Анхан шатны баримтын тулгалтаар 4 харилцагчдаас 3.6 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1	3,646.1					1	3,646.1				

БШУ-ны сайдын 2022 оны А/452 тоот тушаалын дагуу хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтаар 54.1 сая төгрөг шилжүүлсэн ч хөрөнгөө хүлээж аваагүй байна.	1				1							
Дүн	3				1	2						-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 3,302.3 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 2,586.5 сая төгрөгийн 55 гүйлгээ, 47.9 сая төгрөгийн 5 зардал гаргах шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 422.6 сая төгрөгийн орлогын 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 55.6 сая төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 35.1 сая төгрөгийн 8 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1		-	-	1	-		
Дүн	1		-	-	1	-		